



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар

A/19

Модот

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн
орон тооны бус салбар зөвлөл байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66-р зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолын хавсралт “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.3, 2.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга	Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Гишүүд :	ИТХ-ын нарийн бичгийн даргын түр орлон гүйцэтгэгч
	Засаг даргын Тамгын газрын
	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Монгол хэл уран зохиолын багш

2.Холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ